



***“ЮНИСТАР-АУДИТ” ХХК***

**АУДИТОРЫН ТАЙЛАН**

**“НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ” ХК-ИЙН  
2020 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛ УЛС  
2021**

АГУУЛГА

ХУУДАС

1. “НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ” ХК -ИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	2
2. “НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ” ХК-ИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН БОДИТ БАЙДЛЫН ТУХАЙ ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ.....	3
3. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН .....	4
4. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК –ийн 2020 оны 12-р сарын 31-нээрх .....	6
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	6
5. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК-ийн 2020 оны 12-р сарын 31-нээрх.....	7
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН .....	7
6. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК –ийн 2020 оны 12-р сарын 31-нээрх .....	8
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	8
7. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК -ийн 2020 оны 12-р сарын 31-нээрх.....	8
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН .....	8
8. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК -ийн 2020 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тэмдэглэл.....	9
9. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ ...	10
10. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	16
11. ЗӨВЛӨМЖ .....	26

## 1. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК -ИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үүсгэн байгуулах шийдвэр:

Нэхээсгүй эдлэл үйлдвэрийн газар нь 1989 онд байгуулагдсан. 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 1 тоот тогтоолын дагуу хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсан. 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж 2075938 тоот регистрийн дугаар бүхий 9010001017 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

Гол хувьцаа эзэмшигчид:

Б.Ганбат	16.3%
Бэрэн групп ХХК	14.5%
Б.Цэдэнсодном	13.1%
Б.Мөнхтөр	13.1%
Б.Мөнхдалай	13.1%
Б.Ганзориг	13.1%
Б.Лхагвасүрэн	13.1%
Mongolign swan corporation	0.3%
Би ди сек ХХК	0.2%
Tai Tam corporation	0.2%
С.Мягмарсүрэн	0.1%
З.Номундарь	0.1%
Л.Гүндэгмаа	0.1%
Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	2.7%
	100.0%

Компанийн өмчлөл:

Хувийн өмч 100%

- |                             |  |
|-----------------------------|--|
| 1. ТУЗ-ийн дарга            | Б. Ганбат  |
| 2. ТУЗ-ын ердийн гишүүд     | Б. Мөнхтөр<br>Б. Мөнхдалай<br>Г. Мөнхцэцэг<br>Г. Энхболд<br>Ц. Батболд |
| 3. ТУЗ-ын хараат бус гишүүд | П. Золжаргал<br>Л. Амар<br>Б. Мөнхбаяр                                 |

Хаяг: Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, өөрийн байр  
Улаанбаатар хот, Монгол Улс

АУДИТОРУУД:

Юнистар Аудит ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид

**2. “НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ” ХК-ИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН БОДИТ БАЙДЛЫН ТУХАЙ ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ  
УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

“Нэхээсгүй эдлэл” ХК-ийн ерөнхий захирал Б. Ганбат ерөнхий нягтлан бодогч Ц. Намхай бид энэхүү тайлангийн 6-26 дугаар хуудсанд үзүүлсэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх “Нэхээсгүй эдлэл” ХК-ийн санхүүгийн тайлан болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг мэдэгдэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б. ГАНБАТ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Ц. НАМХАЙ



# Юнистар Аудит ХХК

АУДИТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ,  
ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

СБД, 8-р хороо, Амарын гудамж,  
Мигма төв 306 тоот  
Утас: 3287358 99168961, 99994372  
E-mail: info@unistaraudit.mn

2021-04-08 1 0-21/17  
Танай \_\_\_\_\_ № \_\_\_\_\_

## “НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ” ХК-ИЙН УДИРЛАГАД

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Зөрчилгүй дүгнэлт

Бид “Нэхээсгүй эдлэл” ХК-ийн 2020 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөрх жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар, санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Нэхээсгүй эдлэл” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөрх тасалбар болгон бэлтгэсэн жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв толилуулсан байна.

#### Зөрчилгүй дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт(АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд хуулиар шаардсан ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

#### Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, үйл ажиллагаагаа зогсоох эсвэл ингэхээс өөр сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба шаардлагатай бол тасралтгүй байдалтай холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

### Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд нь заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгааг олж авах, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах явдал юм. Ул үндэслэлтэй баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчил бүрийг ямагт илрүүлнэ гэсэн баталгаа гаргадаггүй. Заль мэх эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсч болох ба тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандаж мэргэжлийн шийдэл гарган ажилласан. Мөн бид:

- ✓ Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн үгсэн хуйвалдах, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох зэргээс шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- ✓ Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэстэй байдлыг үнэлдэг.
- ✓ Мөн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжинд мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байдлын суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ компанийн тасралтгүй байх чадавхид нөлөөлөх нөхцөл байдал, үйл явдал ирээдүйд үүсч болох юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн толилуулга, бүтэц, агуулга, тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- ✓ Бид аудитын цар хүрээ, хугацаа, аудитын явцад олж илрүүлсэн томоохон чухал асуудлууд болон ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар эрх бүхий удирдлагатай харилцдаг.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Нэхээсгүй эдлэл ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн.

ЗАХИРАЛ.МНБ



М.ЭНХЖАРГАЛ

**4. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК –ийн 2020 оны 12-р сарын 31-нээрх  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

(Төгрөгөөр)

Төгрөг

ХӨРӨНГӨ	Тэм	12/31/2019	12/31/2020
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Бусад эргэлтийн бус хөрөнгө		1,000,000.00	1,000,000.00
Урт хугацаат хөрөнгө оруулалт			
Биет бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө		1,391,397,412.86	1,286,771,033.02
<b>НИЙТ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		<b>1,392,397,412.86</b>	<b>1,287,771,033.02</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө			
Урьдчилж төлсөн зардал, тооцоо		5,362,892,134.84	568,009,620.75
Бараа материал		321,537,738.18	188,258,621.91
Бусад авлага		12,768,757.31	12,768,757.31
Татвар, НДШ-ийн авлага		221,805.93	557.24
Дансны авлага		31,331,483.92	10,845,210.45
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		8,011,608.89	87,029,512.70
<b>НИЙТ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>5,736,763,529.07</b>	<b>866,912,280.36</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>7,129,160,941.93</b>	<b>2,154,683,313.38</b>
<b>ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Өмч</b>			
Хувьцаат капитал		128,851,500.00	128,851,500.00
Нэмж төлөгдсөн капитал			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		1,368,666,351.56	1,368,666,351.56
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		83,265,100.97	
Эздийн өмчийн бусад хэсэг			
Хуримтлагдсан ашиг, алдагдал		(12,042,790.23)	123,250,321.44
<b>НИЙТ ӨМЧ</b>		<b>1,568,740,162.30</b>	<b>1,620,768,173.00</b>
<b>Өр төлбөр</b>			
<b>Эргэлтийн бус өр төлбөр</b>			
Урт хугацаат зээл		842,754,613.74	
Бусад урт хугацаат өр төлбөр		381,929,541.03	243,970,875.07
Хойшлогдсон татварын өр			
Эргэлтийн бус өр төлбөрийн дүн		1,224,684,154.77	243,970,875.07
Дансны болон бусад өр төлбөр		4,305,132,636.96	247,980,872.99
Цалингийн өглөг		7,667,219.17	6,140,660.10
Татварын өр		12,534,187.98	16,399,982.22
НДШ-ийн өглөг			
Богино хугацаат зээл			
Урьдчилж орсон орлого		10,402,580.75	19,422,750.00
Эргэлтийн өр төлбөрийн дүн		4,335,736,624.86	289,944,265.31
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>5,560,420,779.63</b>	<b>533,915,140.38</b>
<b>НИЙТ ӨМЧ, ӨР ТӨЛБӨР</b>		<b>7,129,160,941.93</b>	<b>2,154,683,313.38</b>



**5. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК-ийн 2020 оны 12-р сарын 31-нээрх  
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

	Тэм	2019 он	(Төгрөгөөр) 2020 он
Орлого			
Борлуулалтын орлого		745,013,617.19	797,924,510.00
Борлуулалтын өртөг		633,596,328.91	543,902,990.64
<b>Нийт ашиг (алдагдал)</b>		<b>111,417,288.28</b>	<b>254,021,519.36</b>
Түрээсийн орлого		15,836,087.52	17,695,670.01
Хүүний орлого			
Ногдол ашгийн орлого			
Бусад орлого		36,629,422.28	13,934,482.50
Борлуулалт маркетингийн зардал		21,479,204.77	12,423,484.02
Ерөнхий ба удирдлагын зардал		99,393,869.41	107,200,074.47
Санхүүгийн зардал			
Бусад зардал		7,804,314.96	30,750,111.17
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		2,547.37	15,109.46
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)			
Бусад ашиг (алдагдал)			
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>35,207,956.31</b>	<b>135,293,111.67</b>
Орлогын татварын зардал		4,300,972.39	
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>30,906,983.92</b>	<b>135,293,111.67</b>





**6. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК –ийн 2020 оны 12-р сарын 31-нээрх  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

(Төгрөгөөр)

Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг, алдагдал	Нийт дүн	
MNT	MNT	MNT	MNT	MNT	
2019 оны 12 сарын 31- нээрх үлдэгдэл НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	128,851,500.00	1,368,666,351.56	83,265,100.97	(12,042,790.23)	1,568,740,162.30
Залруулсан үлдэгдэл Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	128,851,500.00	1,368,666,351.56	83,265,100.97	-	83,265,100.97
			(12,042,790.23)		1,485,475,061.33
			135,293,111.67		135,293,111.67
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт Зарласан ногдол ашиг Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн 2020 оны 12 сарын 31- нээрх үлдэгдэл	128,851,500.00	1,368,666,351.56	-	123,250,321.44	1,620,768,173.00



**7. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК –ийн 2020 оны 12-р сарын 31-нээрх  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Тэм	2019 он	2020 он
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Мөнгөн орлогын дүн		785,637,926.94	901,754,691.92
Мөнгөн зарлагын дүн		667,819,090.48	606,645,127.21
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		117,818,836.46	295,109,564.71
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(11,301,531.00)	109,857.41
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(103,142,992.38)	(216,201,518.31)
<b>Валютын ханшийн зөрүү</b>			
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		3,374,313.08	79,017,903.81
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,637,295.81	8,011,608.89
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,011,608.89	87,029,512.70
		(0.00)	0.00



## 8. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК -ийн 2020 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тэмдэглэл

Эдгээр тэмдэглэлүүд нь хавсаргасан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээртэй хамт уншигдана.

### А. “НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ” ХК –ийн товч мэдээлэл

- Байршил:  
Хан-Уул дүүрэг ,1-р хороо , Чингисийн өргөн чөлөө, Өөрийн байр
- Өмчийн хэлбэр:  
Хувийн өмчит ХХК РД- 2075938  
Улсын бүртгэлийн дугаар: 9010001017
- Харилцдаг санхүү, татварын байгууллага:  
Сангийн яам
- Тайлангийн хугацаа:  
2020 оны 01 сарын 01-нээс  
2020 оны 12 сарын 31-нийг дуустал
- Удирдлага: ТУЗ-ийн дарга Б. Ганбат  
Захирал Б. Ганбат  
Ерөнхий нягтлан бодогч Ц. Намхай
- Үйл ажиллагааны үндсэн чиглэл:  
Шивмэл эсгий, нимгэн эсгий, оёмол зулхай үйлдвэрлэл  
Гадаад худалдаа

### Үндсэн үйл ажиллагааны товч танилцуулга

Нэхээсгүй эдлэл ХК нь 1989 онд Австрын Ферер, Германы Гроз-Бекерт, Польшийн Бефима, Японы Yamaichi зэрэг орнуудын тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон ноос, ноосон эдлэлийн үйлдвэр ашиглалтанд орсон. Нэхээсгүй эдлэл ХК-ийн үүсгэн байгуулагчийн шийдвэрээр 1995 оны 12-р сард хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсан. Тус компани нь үүсгэн байгуулагдсанаас хойш 26 жилийн туршид үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа тасарилгүй явуулж байгаа шивмэл эсгий, нимгэн эсгий, оёмол зулхай үйлдвэрлэгч Монгол Улсын тэргүүлэгч компани юм.

“Нэхээсгүй эдлэл” ХК нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компани юм.

Төлөөлөн удирдах зөвлөл/ТУЗ/ нь 9 гишүүнтэй, үүнээс хараат бус гишүүн 3 байна. ТУЗ-ийн дарга Б. Ганбат, Гүйцэтгэх захирал Г. Ганбат юм.



## 9. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

### 1. Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл

Нэхээсгүй эдлэл ХК-ийн удирдлага нь Компанийн тухай хуулийн 95 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу компанийн хөрөнгө, эх үүсвэр, санхүүгийн байдал, хүлээн зөвшөөрсөн орлого, зарлага, тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт/СТОУС/, Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу үнэн зөв илэрхийлэх явдал юм.

Нэхээсгүй эдлэл ХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын сатандартын Хорооноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) болон Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэгдсэн байна.

Компанийн тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөг байна.

Санхүүгийн тайлангууд нь доорхи зүйлсээс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

- Санхүүгийн хэрэглүүр-Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжих
- Санхүүгийн хөрөнгө- Зээл ба авлага
- Санхүүгийн өр төлбөр-Хорогдуулсан өртгөөр илэрхийлэх

#### *Нягтлан бодох бүртгэлийн суурь*

Байгууллагын санхүүгийн үзүүлэлтүүдийг хэмжих валют болох Монгол Төгрөгөөр илэрхийлэгдсэн Санхүүгийн тайлангууд нь аккруэл сууриар бэлтгэгдсэн.

#### *Тасралтгүй үйл ажиллагааны зарчим*

Тус компани нь 1995 онд хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсанаас хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Цаашид үйл ажиллагаа тасалдах нөхцөл шалтгаан ажиглагдаагүй бөгөөд байгууллагын санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд тулгуурлан бэлтгэгдсэн.

Нягтлан бодох бүртгэлээ Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу Microsoft Excel программаар хөтөлдөг.

### 2. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг.

Компани ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны талаарх таамаглал гэх мэт бусад хүчин зүйлд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

#### *Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа*

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтанд суурилан тайлант үе бүрийн эцэст барилга байгууламж, тоног төхөөрөмж, компьютер дагалдах хэрэгсэл болон биет бус хөрөнгө зэрэг элэгдүүлдэг хөрөнгийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр



дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болох юм.

#### *Бараа материал*

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар тусгана. Цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо тооцоолол хийх үеийн хамгийн найдвартай бэлэн байгаа нотолгоог авч үздэг. Компанийн бизнес нь технологийн өөрчлөлттэй нягт уялдаатай бол борлуулалтын үнэ нь хурдан өөрчлөгдөж байдаг. Бараа материалын дансны үнийн ирээдүйд гарах өөрчлөлт нь зах зээлийн үнийн өөрчлөлтөөс шалтгаална.

#### *Хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

Хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгж тус бүрийн хувьд аливаа үнэ цэнийн бууралт оршин байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст тодорхойлдог. Тухайн хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийг ашиглах ба худалдан борлуулснаас бий болох бодит үнэ цэнэ нь хөрөнгийн дансны үнээс бага байх тохиолдолд үнэ цэнийн бууралтыг авч үздэг. Бодит үнэ цэнэ нь тухайн арилжааны талаар зохих мэдлэг бүхий оролцогч эсвэл сонирхогч талуудын хоорондын хөрөнгөө худалдах, солилцох тохиролцсон үнээр тодорхойлогдоно.

### **3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд**

#### *а) Санхүүгийн хөрөнгө*

##### *Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө*

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд касс дахь бэлэн мөнгө, санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа мөнгө, бусад богино хугацаатай, 3 сар эсвэл түүнээс богино хугацаанд мөнгө болох чадвартай, үнийн өөрчлөлтөнд өртөмтгий бус хөрөнгө оруулалт болон банкны овердрафт багтана.

##### *Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжислт*

Санхүүгийн хөрөнгийг анх удаа түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэд ажил гүйлгээний зардлыг нэмж оруулна. Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ажил гүйлгээний зардлыг тайлант үеийн ашиг алдагдлаар тайлагнана.

#### **Ангилал**

Санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд хэмжих зорилгоор дараах байдлаар ангилна.

#### *i. Зээл ба авлага*

Зээл ба авлагууд нь идэвхитэй зах зээлийн жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгө юм.

#### *ii. Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө*

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө нь арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан аваад богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай хөрөнгө болон анхнаасаа бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан хөрөнгүүд юм.

Идэвхитэй зах зээлийн жишиг байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх хөрөнгө гэж ангилахгүй.

#### *Дараа үеийн хэмжислт*

Зээл ба авлага, дуусах хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.



Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө болон бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд бодит үнэ цэнээр хэмжинэ. Бодит үнэ цэнээс үүссэн олз, гарзыг дараах байцдаар хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- ✓ Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ашиг, алдагдлын тайланд бусад орлого, бусад зардлаар
- ✓ Гадаад валютаар илэрхийлсэн үнэт цаас бүхий борлуулах боломжтой хөрөнгийн хувьд үнэт цаасны хорогдуулсан өртөгт орсон өөрчлөлттэй холбоотой үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар, дансны үнийн бусад өөрчлөлтийг дэлгэрэнгүй орлогоор
- ✓ Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө гэж ангилсан мөнгөн болон мөнгөн бус үнэт цаасны хувьд бусад дэлгэрэнгүй орлогоор,

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс олсон хүүгийн орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана. Үр ашигт хүүгийн аргаар тооцсон борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө, дуусах хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт болон зээл, авлагын хүүг ашигт, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

*Үл хүлээн зөвшөөрөлт*

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- ✓ Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалын хүлээн авах эрхийн хугацаа дууссан, эсвэл
- ✓ Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг авах эрхийг шилжүүлсэн бөгөөд (а) санхүүгийн хөрөнгийн эрсдэл, өгөөж бүрэн шилжсэн, эсвэл (б) бүх эрсдэл, өгөөж болон хөрөнгийг шилжүүлээгүй боловч захирах эрхийг нь шилжүүлсэн байх.

*Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой бууралт байгаа бол уг хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

i) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө

Зээл ба авлагын хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн бууралтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар бүртгэнэ.

ii) Борлуулах боломжтой хөрөнгө

Борлуулах боломжтой хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө нь хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүгээр хуримтлагдсан алдагдлаар өмчийг бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн хугацаанд ашиг алдагдал руу буцаахгүй.

Борлуулах боломжтой хөрөнгө гэж ангилсан өрийн үнэт цаасны бодит үнэ цэнэ дараагийн үеүдэд өссөн бол уг өсөлт нь өмнөх хугацаанд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын дараа тохиолдсон үйл явдлаас хамаарсан эсэхийг тодорхойлж, ашиг алдагдлыг буцаана.

b) Санхүүгийн өр төлбөр

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилна:

- ✓ Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр
- ✓ Бусад санхүүгийн өр төлбөр

*Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэ ангилалд багтсан санхүүгийн өр



төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж, гаргадаг. Үүнээс бусад арилжаалагдах, эсвэл үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

*Бусад санхүүгийн өр төлбөр*

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- ✓ Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг тайлангийн үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүний зардалд анхны гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү, эсвэл купон багтана.
- ✓ Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүний түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Компани санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

Нөхөн сэргээлтийн нөөц нь өмнөх үеийн үйл явдлынүр дүнд, ирээдүйн цаг хугацаа болоод мөнгөн дүнгийн хувьд тодорхой бус хуулийн дагуух хариуцлага үүссэн үед хүлээн зөвшөөрөгдөнө. Тайлангийн өдрөөрх нөөцийн дүн нь ирээдүйн нөхөн сэргээлтэд шаардагдах зардлын өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдэнэ.

*с) Үндсэн хөрөнгө*

*Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Үндсэн хөрөнгө нь хуримтлагдсан элэгдэл хассан цэвэр дүнгээр тайлагнагдсан. Түүхэн өртөг нь худалдан авахтай холбоотой зардлаас бүрдэнэ. Үндсэн хөрөнгөд барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер бусад хэрэгсэл болон бусад хөрөнгө бүртгэгдсэн байна. Үндсэн хөрөнгийг данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулан тодорхойлж, орлогын тайланд ашиг, алдагдлаар тусгана.

*Элэгдэл*

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг.

*д) Эздийн өмч*

Энгийн хувьцааг өмчөөр бүртгэсэн.

Хуримтлагдсан ашиг нь үйл ажиллагаа эхэлсэн үеэс хуримтлагдаж, ногдол ашиг хуваарилсны дараа үлдэж буй цэвэр ашиг юм.

*е) Орлого*

Эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай болсон ба орлогыг бодитойгоор хэмжих боломжтой болсон үед орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэх ба аливаа хөнгөлөлт, буцаалт болон үнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр нь тайланд тусгана.

*Хүүний орлого*

Хүүний орлогыг үндсэн зээл буюу хэрэглүүрийн үлдэгдэл болон холбогдох харилцах хадгаламжийн үлдэгдэл, үр ашигт хүүний түвшинээр тооцож, аккруэл сууриар хүлээн зөвшөөрнө.



f) *Өртөг ба Зардал*

Хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг. Зардлыг орлогын нэгэн адил аккумуляр сууриар бүртгэсэн. Зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үндсэн бус үйл ажиллагааны зардал ба гарз гэж ангилж бүртгэсэн. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь борлуулалтын орлогод ногдох бүтээгдэхүүний өртөг юм.

Өртөг зардлыг тайлант хугацааны ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

g) *Санхүүгийн орлого, зардал*

Санхүүгийн орлогод харилцах, хадгаламжийн үлдэгдэлд бодогдсон хүүний орлого болон бусад холбоотой талуудад олгосон зээлийн хүүний орлого, богино хугацаат бондын хүүний орлого зэргийг хамруулна. Хүүний орлогыг олсон тайлант үеийнх орлогын тайланд тусгана.

*Зээлийн хүүний зардал*

Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах эсвэл үйлдвэрлэхтэй шууд холбоотой зээлийн хүүгийн зардлыг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгох зорилгоор хөрөнгийг бэлтгэх болон бүрэн дуусгахад шаардлагатай хугацааны туршид капиталжуулна. Бэлтгэх ажиллагаа шаардлагатай хөрөнгө гэдэг нь хөрөнгийг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болтол тодорхой хугацаа шаардлагатай хөрөнгө юм.

h) *Ханшийн зөрүүг хүлээн зөвшөөрөх*

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон авлага, өглөгийг тайлагналын өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээг гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Хөрвүүлэлтээс үүдэлтэй гадаад валютын ханшийн зөрүү нь орлогын тайланд тайлагнагдсан.

i) *Татварын бүртгэл*

*Орлогын албан татвар*

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэгжиж байсан хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн татварын зардал болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн жилд эсвэл өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэснээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зардалд хүлээн зөвшөөрөгдөнө.

j) *Холбоотой талууд*

Компанид дараах талуудыг холбоотой талууд гэж үздэг.

а. Компанийн шууд эсвэл шууд бусаар хянадаг эсвэл хянагддаг, эсвэл нэгдсэн хяналтанд багтдаг компаниуд,

б. Хараат компаниуд,

в. Компанийн саналын эрхтэй хувьцааг шууд эсвэл шууд бусаар эзэмшиж томоохон нөлөө үзүүлдэг хувь хүмүүс эсвэл тэдгээр хувь хүмүүсийн гэр бүлийн гишүүд,

г. Компанийн үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, хянах эрх ба үүрэгтэй удирдлагын гол ажилтнууд, үүнд компанийн захирлууд ба удирдах ажилтнууд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд,

д. Компанийн саналын эрхтэй хувьцааны дийлэнх хувийг шууд эсвэл шууд бусаар эзэмшдэг (в) ба (г)-д тодорхойлсон хувь хүмүүс эсвэл тэдгээр хүмүүс нь томоохон нөлөө үзүүлдэг. Компанийн гол удирдлагад нэг гишүүн нь болж байгаа компаниуд мөн багтана.

к) *Болзошгүй зүйлс*

Хэрэв өнгөрсөн үйл явдлын үр дүнгээс хамааран компани нь хууль ёсны эсвэл практик үүрэг хариуцлагыг хүлээж байгаа бөгөөд энэ хариуцлагыг зохих ёсоор тодорхойлох боломжтой ба эдийн засгийн үр өгөөжөөр уг хариуцлагыг барагдуулах боломжтой үед болзошгүй зүйлсийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.





## 10. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 1) Тодруулга-Эргэлтийн бус хөрөнгө, элэгдэл

Балансын өдрөөрх байгууллагын эргэлтийн бус хөрөнгө, хөрөнгийн элэгдэл дансны үлдэгдлийг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

Ангилал	Тайлбар	/төгрөгөөр/			
		2019/12/31-ний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	2020/12/31-ний үлдэгдэл
Барилга байгууламж	Хөрөнгө	1,137,357,397.75			1,137,357,397.75
	Хуримтлагдсан элэгдэл	455,895,891.41	28,433,934.94		484,329,826.35
Машин тоног төхөөрөмж	Хөрөнгө	1,117,656,367.04	13,342,500.00		1,130,998,867.04
	Хуримтлагдсан элэгдэл	530,271,936.94	72,694,404.70		602,966,341.64
Тавилга, эд хогшил	Хөрөнгө	101,697,140.40	7,476,272.73	9,649,757.68	99,523,655.45
	Хуримтлагдсан элэгдэл	67,839,128.70	9,052,679.97	9,649,757.68	67,242,050.99
Тээврийн хэрэгсэл	Хөрөнгө	197,946,592.73			197,946,592.73
	Хуримтлагдсан элэгдэл	119,057,709.54	17,753,993.35		136,811,702.89
Компьютер дагалдах хэрэгсэл	Хөрөнгө	18,878,943.31	5,544,454.54	3,449,741.00	20,973,656.85
	Хуримтлагдсан элэгдэл	9,074,361.78	3,054,594.15	3,449,741.00	8,679,214.93
<b>НИЙТ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>2,573,536,441.23</b>	<b>26,363,227.27</b>	<b>13,099,498.68</b>	<b>2,586,800,169.82</b>
	<b>ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ</b>	<b>1,182,139,028.37</b>	<b>130,989,607.11</b>	<b>13,099,498.68</b>	<b>1,300,029,136.80</b>
<b>НИЙТ ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГ</b>		<b>1,391,397,412.86</b>	<b>(104,626,379.84)</b>	<b>-</b>	<b>1,286,771,033.02</b>

### 2) Тодруулга-Бусад эргэлтийн бус хөрөнгө

	2019/12/31 -ний үлдэгдэл	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилцагч- лын тоо	/төгрөгөөр/ Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо-нд	1,000,000.00	1,000,000.00	1.00	-	-
	1,000,000.00	1,000,000.00	1.00	-	-



### 3) Тодруулга-Урьдчилж төлсөн зардал тооцоо

Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа болон урьдчилан төлсөн зардлуудыг урьдчилж гарсан төлбөр (зардал) гэнэ. Энэ нь төлбөр хийгдсэн боловч тайлант хугацаанд гараагүй байгаа зардал учраас хөрөнгө гэж бүртгэгдэнэ.

Балансын өдрөөрх байгууллагын урьдчилж төлсөн зардал тооцоо дансны үлдэгдлийг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

	2019/12/31 -ний үлдэгдэл	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилцагч дын тоо	/төгрөгөөр/ Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Урьдчилж төлсөн зардал	5,362,892,134.84	568,009,620.75	1.00	(4,794,882,514.09)	(89.41)
	<u>5,362,892,134.84</u>	<u>568,009,620.75</u>	<u>1.00</u>	<u>(4,794,882,514.09)</u>	<u>(89.41)</u>

Урьдчилж төлсөн зардал дансанд Архангай аймгийн Хотонт суманд ноос угаах үйлдвэр барьсан бөгөөд зардлыг хуримтлуулан бүртгэсэн байна. Үйлдвэрлэл ашиглалтанд ороход бэлэн болсон бөгөөд Улсын комисст хүлээлгэж өгөөгүй, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг аваагүй байгаа.

### 4) Тодруулга-Бараа материал

Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор бэлтгэсэн түүхий эд материал, хангамжийн материал болон бэлэн бүтээгдэхүүн нь бараа материалын бүртгэлд бүртгэгдсэн байна. Бараа материалын өртөг нь худалдаж авсан өртгөөр тодорхойлогдоно.

Балансын өдрөөрх байгууллагын бараа материал дансны үлдэгдлийг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

	2019/12/31 -ний үлдэгдэл	2020/12/31 -ний үлдэгдэл	/төгрөгөөр/ Өөрчлөлт		
			Дүн	Хувь	
Түүхий эд материал	240,210,627.21	117,744,039.55	(122,466,587.66)	(104.01)	
Бэлэн бүтээгдэхүүн	60,470,760.91	48,959,022.73	(11,511,738.18)	(23.51)	
Бараа	7,742,288.14	6,070,561.71	(1,671,726.43)	(27.54)	
Хангамжийн материал	1,685,586.02	1,685,586.02	-	-	
БҮТЭЭ	11,428,475.90	13,799,411.90	2,370,936.00	17.18	
	<u>321,537,738.18</u>	<u>188,258,621.91</u>	<u>-</u>	<u>133,279,116.27</u>	<u>70.80</u>

### 5) Тодруулга-Татвар, НДШ-ийн авлага

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад татвар, төлбөр хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

Балансын өдрөөрх байгууллагын татвар, НДШ-ийн авлага дансны үлдэгдлийг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

	2019/12/31 -ний үлдэгдэл	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилц агчдын тоо	/төгрөгөөр/ Өөрчлөлт	
				Дүн	Хувь
НДШ-ын авлага	221,805.93	557.24	1	(221,248.69)	(39,704.38)
	<u>221,805.93</u>	<u>557.24</u>	<u>1</u>	<u>221,248.69</u>	<u>39,704.38</u>



## б) Тодруулга-Авлага

Авлагыг юуны авлага болох, байгууллага, хүмүүс гэх мэт төрлөөр ангилж, тайлан тэнцэлд байрлуулан нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгана.

Балансын өдрөөрх байгууллагын авлага дансны үлдэгдлийг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

	2019/12/31 -ний үлдэгдэл	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилцагч дийн тоо	/төгрөгөөр/ Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Дансны авлага	31,331,483.92	10,845,210.45		(20,486,273.47)	(188.90)
Бусад авлага	12,768,757.31	12,768,757.31		-	-
	44,100,241.23	23,613,967.76	-	(20,486,273.47)	(86.75)

Авлага дансны үлдэгдэл 20,486.3 мянган төгрөгөөр буурсан нь зээлээр борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээнийхээ төлбөрийг худалдан авагч, харилцагч этгээдээс авлагаа цуглуулсантай холбоотой байна. Нийт 23,613.9 мянган төгрөгийн дансны авлагатай бөгөөд авлагатай байгууллага, хувь хүмүүсүүдэд тулган баталгаажуулах захидал илгээхэд 7,328.4 мянган төгрөгийн авлагын тулган баталгаажуулах захидлын хариу ирсэн бөгөөд 16,285.5 мянган төгрөгийн авлагад холбоо барих боломжгүй 16,149.2 байна. Авлага удах тусам чанаргүйдэж зардал өсдөг мөн хугацаа алддаг. Энэ нь компанид мөнгөний хомсдолыг үүсгэж байдаг.

### 6.1 Дансны авлага

	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилцагч дийн тоо	Хувь	Тайлбар
Ар ган ХХК	297,000.00	1	2.74	
Хөх ган ХХК	504,850.00	1	4.66	
Бэрэн мортгейж ХХК барааны үнэ	607,254.00	1	5.60	
Борлуулалт Мөнхгэрэл иргэн Нармандал	2,702,351.00	1	24.92	
Тэгшрэх 3-н эрдэнэ ХХК	814,530.00	1	7.51	
Эрдэнэт стилл ХХК хоол	931,200.00	1	8.59	
Бэрэн металл ХХК хоол	2,972,775.45	1	27.41	
Бэрэн секьюрити ХХК хоол	225,360.00	1	2.08	
Бэрэн констракшн ХХК	529,890.00	1	4.89	
П.Мөнхтуяа зээл авав	1,010,000.00	1	9.31	
Т.Ганчулуун зээл	250,000.00	1	2.31	
	10,845,210.45	11	100	

## 7) Тодруулга-Мөнгөн хөрөнгө

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгөний болон банкин дахь мөнгөний үлдэгдлээс бүрдэнэ.

Балансын өдрөөрх байгууллагын мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

КАСС	валют	12/31/2019		12/31/2020		/төгрөгөөр/ өөрчлөлт	
		доллар	төгрөг	доллар	төгрөг	доллар	төгрөг
	MNT		1,281,016.00		4,209,970.00		2,928,954.00
нийт		-	1,281,016.00	-	4,209,970.00	-	2,928,954.00
Худалдаа хөгжлийн банк	MNT		41,978.19		41,978.19	-	-
Худалдаа хөгжлийн банк	MNT		13,607.70		1,607.70	-	(12,000.00)
Худалдаа хөгжлийн банк	USD	39.64	108,388.84	35.39	100,857.60	(4.25)	(7,531.24)
Хаан банк	MNT		6,214,664.00		82,368,871.41	-	76,154,207.41
Хаан банк	CNY	143.02	56,119.62	84.21	36,734.93	(58.81)	(19,384.69)
Голомт банк	MNT		7,000.77		-	-	(7,000.77)
Голомт банк	USD	53.38	145,958.54	48.78	139,017.64	(4.60)	(6,940.90)
Хас банк	MNT		142,875.23		130,475.23	-	(12,400.00)
нийт		236.04	6,730,592.89	168.38	82,819,542.70	(67.66)	76,088,949.81
нийт мөнгөн хөрөнгө		236.04	8,011,608.89	168.38	87,029,512.70	(67.66)	79,017,903.81

Мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд 1-р гарын үсгийг Гүйцэтгэх захирал Б.Ганбат, 2-р гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Ц. Намхай зурдаг.

Мөнгөн хөрөнгийг аудитын горимын дагуу шалгахад харилцах дансдын үлдэгдлийг тулган баталгаажуулалт явуулж, аудитын горимыг гүйцэтгэхэд 2020 оны 12-р сарын 31-ний байдлаарх төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл тохирч байна.

## 8) Тодруулга-Богино хугацаат өр төлбөр

Өр төлбөр нь байгууллагын бусдын өмнө хүлээсэн эдийн засгийн хариуцлага юм. Богино хугацаат өр төлбөрийг доорхи байдлаар тайлагнасан. Үүнд:

	2019/12/31 -ний үлдэгдэл	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилцагчдын Тоо	/төгрөгөөр/ Өөрчлөлт		Тайлбар
				Дүн	Хувь	
Дансны өглөг	4,305,132,636.96	247,980,872.99		(4,057,151,763.97)	(100.00)	
Цалингийн өглөг	7,667,219.17	6,140,660.10		(1,526,559.07)	(24.86)	
Татварын өр	12,534,187.98	16,399,982.22		3,865,794.24	23.57	
Урьдчилж орсон орлого	10,402,580.75	19,422,750.00		9,020,169.25	46.44	
	4,335,736,624.86	289,944,265.31	-	(4,045,792,359.55)		

Өглөгийн дансны үлдэгдэл 4,057,151.8 мянган төгрөгөөр буурсан нь бэлтгэн нийлэгч байгууллагуудад өгөх төлбөр тооцоог барагдуулснаас шалтгаалжээ.

Татварын өр дансдын үлдэгдэл өссөн нь хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоог барагдуулаагүйтэй холбоотой.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл нь 9,020.2 мянган төгрөгийн худалдан авагч, захиалагчаас хүлээн авсан мөнгөөр өссөн байна.

### 8.1 Дансны өглөг

	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилцагчдын тоо	Хувь	Тайлбар
Цэрэнпэлжээ хоорондын тооцоо	2,190,000.00	1	0.88	
Лхагвадорж эсгийний үнэ	2,680,000.00	1	1.08	
Бэрэн групп ХХК	58,378,114.99	1	23.54	
Qingday Yuanquan Machinery Co.,Ltd	96,998,258.00	1	39.12	
Батсүх ноосны үнэ	3,398,400.00	1	1.37	
Дашзэвгээс эсгийний үнэ	4,815,500.00	1	1.94	
Хотонт ноос ХХК	53,706,100.00	1	21.66	
ШШГЕГазар Э.Эрдэнэцогт	51,500.00	1	0.02	
Янживаас төлбөр	1,850,000.00	1	0.75	
А.Баасанжаргалаас зээлэв	23,913,000.00	1	9.64	
	<b>247,980,872.99</b>	<b>10</b>	<b>100</b>	

### 8.2 Татварын өглөг

	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилцагчдын тоо	Хувь	Тайлбар
НӨАТ-н өглөг	13,546,262.54	1	82.60	
ХХОАТ-н өглөг	2,842,719.68	1	17.33	
Бусад татварын өглөг	11,000.00	1	0.07	
	<b>16,399,982.22</b>	<b>3</b>	<b>100</b>	

### 9) Тодруулга-Урт хугацаат өр төлбөр

Аж ахуйн нэгжийн урт хугацаатай банкны зээл, бондын өр төлбөр, барьцаат өр төлбөрийн санхүүгийн тайлант жилийн дараах нэг жилд төлөгдөх хэсгийг богино хугацаат өр төлбөрт шилжүүлж бүртгэнэ.

Балансын өдрөөрх байгууллагын урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдлийг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

	2019/12/31 -ний үлдэгдэл	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилцагчдын тоо	Өөрчлөлт /төгрөгөөр/		Тайлбар
				Дүн	Хувь	
Урт хугацаат зээл /Голомт банк/	842,754,613.74			(842,754,613.74)	(100.00)	
Бусад урт хугацаат өр төлбөр	381,929,541.03	243,970,875.07		(137,958,665.96)	(56.55)	
	<b>1,224,684,154.77</b>	<b>243,970,875.07</b>	<b>-</b>	<b>(980,713,279.70)</b>		

### 9.1 Бусад урт хугацаат ор төлбөр

	2020/12/31 -ний үлдэгдэл	Харилцагчдын тоо	Хувь	Тайлбар
Бэрэн мортгейж ХХК	10,093,500.00	1	4.14	
АР ИЙ СИ ХХК түрээсийн барьцаа	783,200.00	1	0.32	
Интернэйшнл Медикал ХХК барьцаа	2,027,800.00	1	0.83	
Эм Эм Жи капитал ХХК	5,376,800.00	1	2.20	
Иргэн Чойжилсүрэн материалын үнэнд	73,560.00	1	0.03	
Хорол коллекшн ХХК	530,000.00	1	0.22	
Уран нинж ХХК	5,266,850.00	1	2.16	
Жи Эс Ф ХХК Алтантөр ноос	8,551,736.69	1	3.51	
Лидер кашемир ХХК	21,358,247.50	1	8.75	
Захирал Б.Ганбат тооцоо	163,775,678.35	1	67.13	
Чойрхайрхан ХХК	2,500,000.00	1	1.02	
Атар-Өргөө ХК	2,499,688.80	1	1.02	
ЭБЦТС ХК цахилгааны үнэ	189,570.73	1	0.08	
Инэл кашимер ХХК	18,200,000.00	1	7.46	
Эвт түмэн ХХК ноосны үнэ	2,740,000.00	1	1.12	
Эрдэнэт стил ХХК хоолны үнэ	4,243.00	1	0.00	
	<b>243,970,875.07</b>	<b>16</b>	<b>100</b>	

### 10) Тодруулга-Эздийн өмч ба бусад хэсэг

Эздийн өмч буюу өөрийн хөрөнгө гэж аж ахуйн нэгж нь бүх өр төлбөрийг барагдуулсны дараах хөрөнгө дэх үлдэх хувь оролцоог хэлнэ.

Балансын өдрөөрх байгууллагын эздийн өмч дансны үлдэгдлийг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

	2019/12/31 -ний үлдэгдэл	2020/12/31 -ний үлдэгдэл	Өөрчлөлт	/төгрөгөөр/
Хувьцаат капитал	128,851,500.00	128,851,500.00	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,368,666,351.56	1,368,666,351.56	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	83,265,100.97		(83,265,100.97)	
Хуримтлагдсан ашиг	(12,042,790.23)	123,250,321.44	135,293,111.67	
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,568,740,162.30</b>	<b>1,620,768,173.00</b>	<b>52,028,010.70</b>	

Нэхээсгүй эдлэл ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах ба нэг бүр нь 100.00 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,288,515 ширхэг хувьцаанаас бүрддэг бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 128,851,500.00 төгрөг байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл нь 135,293,111.67 төгрөгөөр өссөн нь тайлант онд ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

### 11) Тодруулга-Нийт орлого

Тайлант жилд байгууллагын орлогыг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

	2019 он	2020 он	Зөрүү	/төгрөгөөр/
Борлуулалтын орлого	745,013,617.19	797,924,510.00	52,910,892.81	
Түрээсийн орлого	15,836,087.52	17,695,670.01	1,859,582.49	
Бусад орлого	36,629,422.28	13,934,482.50	(22,694,939.78)	
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	2,547.37	15,109.46	12,562.09	
<b>Борлуулалтын орлогын дүн</b>	<b>797,481,674.36</b>	<b>829,569,771.97</b>	<b>32,088,097.61</b>	



12) Тодруулга-Нийт зардал

Тайлант жилд зардлыг дараах байдлаар хуримтлуулан бүртгэсэн.

	2019 он	2020 он	/төгрөгөөр/ Өөрчлөлт
<b>Борлуулсан бүтээгдхүүний өртөг</b>	633,596,328.91	543,902,990.64	(89,693,338.27)
<b>Үйл ажиллагаа (борлуулалт, ерөнхий удирдлага)- ны зардал</b>			-
Үндсэн болон нэмэгдэл цалин	66,064,590.45	66,872,150.42	807,559.97
Нийгмийн даатгалын шимтгэл	8,918,719.71	3,934,880.95	(4,983,838.76)
	621,729.00	716,640.00	94,911.00
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал			
Албан томилолтын зардал	6,238,247.11	866,479.54	(5,371,767.57)
Бичиг хэргийн зардал	252,570.00	178,524.27	(74,045.73)
Тээврийн зардал	300,000.00		(300,000.00)
Мэргэжлийн үйлчилгээний зардал	1,701,100.00	2,454,545.45	753,445.45
Элэгдлийн зардал	26,237,702.36	34,815,542.89	8,577,840.53
Шуудан холбооны зардал	4,091,687.85	3,451,137.79	(640,550.06)
Засварын зардал	812,300.00	2,313,418.19	1,501,118.19
Сонин сэтгүүл захиалгын зардал	44,636.36	145,454.55	100,818.19
Шатахуун	3,614,100.94	2,333,900.76	(1,280,200.18)
Хүлээн авалтын зардал	77,090.91	436,363.64	359,272.73
Сургалтын зардал			-
Бусад зардал	1,898,599.48	1,104,519.86	(794,079.62)
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>120,873,074.17</b>	<b>119,623,558.31</b>	<b>(1,249,515.86)</b>
<b>Татварын зардал</b>	<b>4,300,972.39</b>		<b>(4,300,972.39)</b>
<b>Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)</b>			-
Бусад үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	7,804,314.96	30,750,111.17	22,945,796.21
<b>Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал</b>	<b>7,804,314.96</b>	<b>30,750,111.17</b>	<b>22,945,796.21</b>
<b>Нийт зардлын дүн</b>	<b>766,574,690.43</b>	<b>694,276,660.12</b>	<b>(72,298,030.31)</b>



13) Тодруулга-Мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн дугаа ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1 Мөнгөн орлогын дүн (+)	785,637,926.94	901,754,691.92
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	709,914,934.89	709,795,384.92
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,668,686.00	1,684,386.00
Бусад орлого	74,054,306.05	190,274,921.00
1.2 Мөнгөн зарлагын дүн (-)	667,819,090.48	606,645,127.21
Ажиллагчдад төлсөн	186,372,039.93	188,231,661.99
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	54,889,325.13	20,620,818.10
Бараа материал худалдан авахад төлсөн	200,656,770.00	179,748,352.37
Ашиглалтын зарлалд төлсөн	66,542,980.61	64,749,179.32
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	33,931,495.00	22,135,711.29
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	101,190,403.55	105,998,696.51
Даатгалын төлбөрт төлсөн	3,010,537.00	1,684,386.00
Бусад мөнгөн зарлага	21,225,539.26	23,476,321.63
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	117,818,836.46	295,109,564.71
2 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1 Мөнгөн орлогын дүн (+)	-	12,037,414.97
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацааны хөрөнгө борлуулсны орлого		
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		12,037,414.97
Хүлээн авсан хүүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
2.2 Мөнгөн зарлагын дүн (-)	11,301,531.00	11,927,557.56
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,301,531.00	7,976,272.73
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусад олгосон зээл болон урьдчилгаа		3,951,284.83
2.3 Хөрөнгө оруулалтын ү/а-ны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,301,531.00)	109,857.41
3 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1 Мөнгөн орлогын дүн (+)	2,100,012,057.30	633,115,595.33
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,100,000,000.00	633,100,000.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Бусад орлого	12,057.30	15,595.33
3.2 Мөнгөн зарлагын дүн (-)	2,203,155,049.68	849,317,113.64
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,203,151,544.10	849,317,113.64
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Бусад мөнгөн зарлага	3,505.58	
3.3 Санхүүгийн ү/а-ны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(103,142,992.38)	(216,201,518.31)
Валютын зөрүү		
4 Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,374,313.08	79,017,903.81
5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,637,295.81	8,011,608.89
6 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,011,608.89	87,029,512.70
	0.00	-





**14) Тодруулга-Холбоотой талууд**

Тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтанд шууд болон шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани нь өөрийн удирдлага, хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харилцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байна.

Тус компанийн хувьд доор дурдсан аж ахуйн нэгж, хувь хүмүүс холбоотой талууд байна.

Холбоотой талын нэр	Харьяалал	Холбоо, хамаарал
Б. Ганбат	Монгол Улсын иргэн	ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал, Нэхээсгүй эдлэл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч
Б. Мөнхтөр	Монгол Улсын иргэн	ТУЗ-ийн хараат гишүүн, Нэхээсгүй эдлэл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч
Б. Мөнхдалай	Монгол Улсын иргэн	ТУЗ-ийн хараат гишүүн, Нэхээсгүй эдлэл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч
Ц. Батбаяр	Монгол Улсын иргэн	ТУЗ-ийн хараат гишүүн
Г. Энхболд	Монгол Улсын иргэн	ТУЗ-ийн хараат гишүүн
Ц. Батболд	Монгол Улсын иргэн	ТУЗ-ийн хараат гишүүн
Л. Түвшинбат	Монгол Улсын иргэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Ц. Энхтүвшин	Монгол Улсын иргэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн
П. Цэрэнбаатар	Монгол Улсын иргэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Бэрэн групп ХХК	Монгол Улсын хуулийн этгээд	Нэхээсгүй эдлэл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч
Б. Цэдэнсодном	Монгол Улсын иргэн	Нэхээсгүй эдлэл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч
Б. Ганзориг	Монгол Улсын иргэн	Нэхээсгүй эдлэл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч
Б. Лхагвасүрэн	Монгол Улсын иргэн	Нэхээсгүй эдлэл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч
Хөх ган ХК	Монгол Улсын хуулийн этгээд	Бэрэн ХХК-ийн хамаарал бүхий компани
Бэрэн мортгейж ХХК	Монгол Улсын хуулийн этгээд	Бэрэн ХХК-ийн хамаарал бүхий компани
Бэрэн металл ХХК	Монгол Улсын хуулийн этгээд	Бэрэн ХХК-ийн хамаарал бүхий компани
Бэрэн секьюрити ХХК	Монгол Улсын хуулийн этгээд	Бэрэн ХХК-ийн хамаарал бүхий компани
Бэрэн констракшн ХХК	Монгол Улсын хуулийн этгээд	Бэрэн ХХК-ийн хамаарал бүхий компани
Хотонт ноос ХХК	Монгол Улсын хуулийн этгээд	Харилцагч компани
Интернэйшнл Медикал ХХК	Монгол Улсын хуулийн этгээд	Харилцагч компани



**15) Болзошгүй алдагдал**

Санхүүгийн тайлангийн тодруулга 3 Урьдчилж төлсөн тооцоо дансанд багтсан Архангай аймгийн хотонт суманд баригдсан ноосны үйлдвэртэй холбоотой 568,009.6 мянган төгрөгийн урьдчилж төлсөн зардлын тооцоог хийж, үндсэн хөрөнгө дансанд бүртгээгүй байна.

**16) Эрсдэлийн удирдлага**

Компанид санхүүгийн эрсдэл үүсч болох дараах хөрөнгүүд байна.

- Авлага болон бусад авлага
- Дансны өглөг болон урт хугацаат өр төлбөр

Удирдлага нь компанийн эрсдэлийн удирдлагын бодлогод гол үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ түүнийг тодорхойлж, бэлтгэх үүрэгтэй.

Удирдлага компанийн өрсөлдөх чадвар, уян хатан байдалд хэт нөлөөлөхгүйгээр эрсдэлийг аль болох бууруулах бодлого баримтлах хэрэгтэй.

**17) Зэрэгцүүлсэн мэдээлэл**

Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангаар илэрхийлэгдсэн дүнг эдгээр санхүүгийн тайлантай нийцүүлэх зорилгоор зарим мэдээллийг дахин ангилсан болно.



## 11. ЗӨВЛӨМЖ

### 1. НББ-ийн бодлогын баримт бичгийн талаар

#### Бодит байдал

Компани өөрийн нягтлан бодох бүртгэлдээ дагаж мөрдөх НББ-ийн бодлогын баримт бичиг байхгүй.

#### Шаардлага

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд:

3.1.9-д “НББ-ийн бодлогын баримт бичиг” гэдэг нь бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг хэлнэ гэж заасан байдаг

18.2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана гэж заасан.

#### Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, захирлын тушаалаар баталж, дагаж мөрдөхийг зөвлөж байна.

### 2. Өглөгийн бүртгэлд тавигдах хяналтыг сайжруулах

#### Ажиглалт

Компанийн богино хугацаат өр төлбөр болон урт хугацаат өр төлбөрийн бүртгэлд төлөгдөх эсэх нь тодорхойгүй 177,344.2 мянган төгрөгийн тооцоо нийлсэн акт байхгүй бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх өр төлбөрийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

#### Эрсдэл

Балансад өглөг авлагын дүн бодитойгоор илэрхийлэгдэхгүйд хүрнэ.  
Удирдлагын шийдвэрт сөрөг нөлөө үзүүлнэ.

#### Зөвлөмж

Харилцагчидтай тайлант хугацаа бүрийн эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулж байх хэрэгтэй.

ЮНИСТАР АУДИТ ХХК

2021-04-08

